

# NEMO2 МЭДЭЭ

## Тавтай морилно уу!

Байгаль орчны бодлогын шинэчлэлд зориулсан Нидерланд, Монголын Итгэлийн Сангийн хоёрдугаар үе шат (NEMO2) сүүлийн жилийнхээ хагаст орж байгаа бөгөөд 2007 оноос хойш ихийг амжуулаад байна. Улирал тутам гардаг энэхүү товхимлоороо төслийн сүүлийн үеийн мэдээллийг хүргэх болно. Танд энэ дугаар таалагдана гэдэгт найдаж байна. NEMO2 төслийн талаар 5-р хуудаснаас олж уншина уу.



Судалгааны камер байрлуулж байгаа нь



Хандгай (Alces alces)

## WILDLIFE PICTURE INDEX

**Судалгааны камер** ашиглан дунд болон том биет, хуурай газрын сээр нуруутан амьтдын мониторинг хийх **Зэрлэг амьтдын зурган индекс (WPI)** хэмээх биологийн олон янз байдлын судалгаа (Таунсенд, Галтбалт, Мягмар 2010)-ны тухай бид өнгөрсөн оны нэгэн дугаартаа танилцуулсан билээ. Тус судалгааны баг хээрийн судалгаагаа дуусаад үр дүнгээ танилцуулах **семинар** зохион байгуулсан юм. Өнгөрсөн 9-р сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулсан уг сургалт семинарт байгаль орчны салбарын холбогдох хүмүүс уригдан оролцлоо. Энд судалгааны үр дүнгээс гадна аргагүй, цаашид хийх ажлын санал зөвлөмжийг танилцууллаа. Семинарын төгсгөлд уг судалгааг хэрхэн үргэлжлүүлэх талаар хэлэлцүүлэг өрнөж, мөн эцсийн тайланд тусгавал зохих үнэтэй санал зөвлөгөөг тус семинарт оролцогсад судалгааны багийнханд өгсөн юм. Монгол орны нийгэм, эдийн засаг хурдацтай өөрчлөгдөж байна. Үүнтэй зэрэгцээд хулгайн ан, зэрлэг амьтдын худалдаа, эдийн засгийн хөгжил зэрэг нь хүрээлэн буй орчинд аюул учруулж байна. Зэрлэг амьтдын зурган индекс судалгаа нь зэрлэг амьтдын тохиолдоцын талаарх суурь мэдээлэл, түүнийг зурагжуулах хандлагыг

бий болгосоноор **биологийн олон янз байдлын хамгааллын** асуудалд тодорхой үүрэг гүйцэтгэх юм. Сонгож авсан судалгааны талбайд дулааны зөрөө болон хөдөлгөөн мэдэрч гэрэл зураг авах судалгааны камер байрлуулна. Дулаан юмуу хөдөлгөөний аль нэг нь илрэхэд уг төхөөрөмж дараалсан гурван зураг авч SD картанд хадгалдаг. Гэрэл зургийг ангилан хаягжуулж, хадгалаад **тохиолдоцыг тооцоход** ашиглана. Эндээс зэрлэг амьтдын зурган индексийг судалгааны талбай бүрт тооцох боломжтой. Индексийн утгын өөрчлөлтийг эхний жилийнхтэй нь харьцуулан авч үздэг. Мянган угалзатын байгалийн цогцолборт газрын орчны бүсэд **Индекс** нь 2009 оноос 2010 онд 14.8% өсч, харин 2011 онд 38% (анхныхтайгаа харьцуулахад) буурсан байна. Тус БЦГ-ын онцгой бүсэд уг индекс 2009 оноос 2010 онд 12.6% өсч, 2011 онд буцаад 2009 оны түвшинд хүрч буурсан байна. Үүнээс үзэхэд сүүлийн гурван жилийн хугацаанд биологийн олон янз байдал харьцангуй тогтвортой байсан гэж үзэж болно. Монгол оронд Зэрлэг амьтдын зурган индексийн судалгаа

хийх явцад уг камерыг ашиглан шувуу болон хөхтөн амьтдын төрөл зүйлийн **олон мянган гэрэл зураг, ихээхэн мэдээлэл** цуглуулж, зүйл тус бүрийн тохиолдоцыг маш нарийн тооцоолсон байна. NEMO2 төслийн санхүүжилт энэ жилээр эцэслэж байгаа тул уг судалгааг санхүүжүүлэх өөр эх үүсвэр олох шаардлага тулгарч байна. Үүнчлэн биологийн олон янз байдлын найдвартай мэдээллийг бий болгоход ийм төслүүдийн тогтвортой үргэлжлэх нөхцөл маш чухал юм.

**Уг судалгааны тайлан оны сүүлээр гарах бөгөөд [worldbank.org/nemo](http://worldbank.org/nemo) хаягаар орж үзнэ үү.**



Тарвага (Marmota sibirica)



Бор гөрөөс (Capreolus pygargus)

### Энэ дугаарт:

Зэрлэг амьтдын зурган индекс	1
БОАЖ-ын дэд сайд Ч.Жаргалсайхантай хийсэн ярилцлага	2
Ярилцлагын үргэлжлэл	3
Тэтгэлэгийн жижиг төслүүдтэй танилцав	4
Салбарын хуулийн хийдэл, давхардал, зөрчлийн үнэлгээ	4
НEMO-гийн түүх	5
НEMO2 баг/Холбоо барих хаяг	5

# БОАЖ-ЫН ДЭД САЙД Ч.ЖАРГАЛСАЙХАНТАЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА



БОАЖ-ын дэд сайд Ч.Жаргалсайхан

## Та байгаль орчны тухай юу бодож явдаг вэ, энэ салбарын ажилтай яаж уялдсан бэ?

Монгол хүн бүр өөрийгөө байгаль орчинтой хүйн холбоотой гэж боддог байх. Миний бодол бусдын л адил. Дэд сайдын алба үүргийг хүлээн авсан цагаас эхлэн энэ салбарт ажиллаж байна. Энэ салбарт ирж ажиллах хүртлээ байгаль орчин бидний өдөр тутмын амьдралтай ийм нягт уялдаатай, тулгамдсан асуудал гэж боддоггүй байлаа. Монголчууд бид түүхэндээ уламжлалт ёс заншил, нүүдлийн амьдралын хэв маяг, агуулга, шашин шүтлэгээрээ дамжуулан байгаль дэлхийг эх хэмээн хүндэтгэн дуудаж түүнийгээ хайрлан хамгаалж үр хойч үедээ өвлүүлэн үлдээхдээ байгальд сөрөг хандлагыг цээрлэн хориглох ёс бий болгосон байдаг. Энэ л ёсоор өсөж хүмүүжсэн болохоор хэдийгээр өөр салбарын мэргэжил эзэмшсэн ч орчин үед тодорхой шинжлэх ухаан өөрөө салбар дундын хэрэглээнд очиж прагматик болсон учир байгаль орчны асуудал сэтгэлд ойр бас ойлгомжтой байгаа. Ерөнхийдөө төрсөн цаг мөчөөсөө эхлэн эх дэлхий, байгаль, хүрээлэн буй орчинтойгоо холбоотой амьдарч ажиллаж байна.

## Таны зүрх сэтгэлд хамгийн ойр байдаг НЕМО-гийн ажил?

НЕМО-гийн үйл ажиллагаан дотор олон сайн ажлууд байгаа хэдий ч төслийн зорилгод илүү сайн нийцсэн энэ чиглэлээр хэрэгжиж буй сайн төсөл нь орон нутаг, хүн ард, олон нийтэд үр шим нь тод томруун

харагддаг жижиг төслийн хөтөлбөр гэж боддог. Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид тэр бүр Монгол орны өнцөг булан бүрт хүрч очин нэгж дээр нь хүнтэй тулж ажиллах цаг зав хомс, нөгөө талаас иргэд олон нийтийн өөрсдийнх нь идэвхи оролцоонд тулгуурлан тэдний чадавхи хөгжүүлэх сайн талтай, өнөөгийн нөхцөлд түлхүү хэрэгцээтэй төсөл юм уу гэж хардаг. Судалгааны төслүүд дээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэжил, туршлага, дадлага сайтай экспертүүд бидэнд хэрэгтэй байна. Хийсэн судалгаа нь ажил хэрэгч бодит үр дүнд хүрч байвал сайн байна.

## НЕМО2 төсөл дууссаны дараа БОАЖЯ-наас төслийн үйл ажиллагааг хэрхэн үргэлжлүүлэх вэ?

БОАЖЯ-ны том ололт буюу энэ төслийн үр дүнд төсөл хэрэгжсэн 4 жилийн хугацаанд төсөл зохион байгуулах, хэрэгжүүлэх, дүгнэх, үнэлэх талаар асар их туршлагатай болсон. Боломж гарвал энэ төслийг үргэлжлүүлэх, байгаль орчны бодлого хэрэгжилтийн чиглэлээр олон төсөл санаачлан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Нидерландын Засгийн газраас үзүүлж байсан буцалтгүй тусламж, санхүүжилт нь мөн НЕМО2 төсөл хэрэгжүүлэх хугацаа дуусаж байгаа боловч ер нь байгаль орчны шинэчлэлийн

ажил өөрөө төгсгөлгүй. Бид цаг үе, нийгмийн хөгжлөө дагаад өөрчлөлт шинэчлэлт хийх нь дамжиггүй. Энэ төслийн хүрээнд "Байгаль орчны мастер төлөвлөгөө-2021" боловсруулан салбарын өөрчлөлт шинэчлэлийн стратеги, бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засгийн Газарт өргөн барьж УИХ-аар батлуулна. Энд хүрээнд донор орнуудтай хамтран цаашид хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал гарч ирнэ. Тэгэхээр төслийн ажил тодорхой түвшинд үргэлжилж байна.

## НЕМО төсөл Монгол улсын төлөө юу хийсэн бэ?

"Байгаль орчны шинэчлэл 2" буюу НЕМО2 төсөл нь байгаль орчны асуудал хурцаар тавигдаж манай орны эдийн засгийн чадамж дорой байсан үед Монгол улсад цаг үеэ олсон маш "Чухал" дэмжлэг байсан. Манай орны байгаль орчны бодлого хэрэгжилтэнд өөрийн онцгой үүргээ гүйцэтгэсэн. Энэ дашрамд НЕМО1 төслийн хамт олон, энэ төслийн санаачлагч Тони Виттен болон НЕМО2 төсөл хэрэгжүүлэгч баг хамт олон, Голландын ард түмэн, засгийн газарт талархаж явдгаа илэрхийлье.



Зургийг Koen Claes

### Монгол улсын байгаль орчны өнөөгийн байдалд ямар асуудал, хэрэгцээ тулгараад байна вэ?

Монгол улсын хөгжлийн бодлогод уул уурхайг хөгжүүлэх асуудлыг гол түлхүүр болгож тавьсан учир эдийн засгийн боломж, хүмүүсийн



Зургийг Koen Claes

амьжиргааны түвшин нэмэгдэхийн хэрээр байгаль орчны асуудал улам өргөн хүрээнд тавигдаж байна. Монголчуудад уламжлал шинэчлэлийг хослуулан ажиллах, байгаль орчин эх дэлхийгээ хайрлан хамгаалах хэрэгцээ, оюун санааны их нэгдлийн асуудал тулгараад байгаа гэж бодож байна. Мөн гадна дотны донорууд бидэнтэй хамтран ажиллаж, эв эеэ нэгтгэн ажиллах шаардлага тулгарч байгаа. Түүнээс гадна байгаль орчны аудит, байгалийн нөөцийн данс-бүртгэл гээд төслийн хүрээнд хийж амжаагүй олон шинэ, шинэлэг ажлууд бас байна аа.

### Уул уурхайн сөрөг нөлөөллөөс эдийн засгийн өсөлт, байгаль орчинд үзүүлж буй хохиролд ямар менежмент хийх вэ?

Уул уурхайн сөрөг нөлөөллийг багасгах, хүмүүсийн хандлагыг эерэг болгох, тэргүүний техник технологи, байгальд ээлтэй уул уурхайн үйл ажиллагаатай зэрэгцэн байгаль хамгаалах, сэргээх ажил тасралтгүй хийж байна. Байгалийн нөөц, баялгаас олж байгаа эдийн засгийн ашгаас эргээд байгаль хамгаалалд зарцуулах, олон нийтийн оролцоо, хяналтын менежментийг улам сайжруулмаар байна. Ногоон эдийн засгийг жинхэнэ утгаар нь бодитоор хэрэгжүүлэх, энэ асуудал хариуцсан хүмүүс, албан тушаалтнуудын хариуцлагын механизмыг боловсронгуй болгох ажлыг хойшлуулалгүй хиймээр байна.

### Байгаль орчин, түүний хамгаалал нь таны өдөр тутмын

### амьдралд ямар үүрэг гүйцэтгэж байна вэ? Улаанбаатарын агаарын бохирдол, усны хомсдол, эко хүнс гэх зэрэг өнөөдөр байгаль орчныг хамгаалах асуудал бүх нийтийн үйлс, нэн тэргүүнд шийдэх асуудал болоод байгаа.

Байгаль орчны тулгамдсан асуудлаа шийдэж чадвал миний өдөр тутамд санаа зовдог асуудлууд шийдэгдэнэ. Үүний дотор нэгдүгээрт, миний зээ охин болон монголын бүх хүүхдүүд, монгол хүн бүр үндсэн хуульд заасан эрүүл аюулгүй орчинд амьдарч ажиллах эрхээ эдэлж чадна. Хоёрдугаарт, байгаль орчны тулгамдсан асуудлууд шийдэгдсэнээр эрүүл монгол хүний хийж бүтээх чадвар, боломж нэмэгдэн Монгол улс хөгжинө.

### 10 жилийн дараахь Монгол орны байгаль орчны дүр төрх таныхаар ямар байх бол?

Монгол орны байгаль орчны дүр төрх 10 жилийн дараа өнөдрийнхөөс сэргэж дээшилсэн байна. Хүн бүр байгаль орчноо хамгаалахад хувь нэмрээ оруулан хувийн эдлэн газраа тордож сэргээнэ. Мод, зүлэг, ногоо, цэцэг, жимс тарьж цэцэрлэг байгуулна. Зам харгүй сайжирна. Эко аялал жуулчлал өргөжин хөгжинө. Ан амьтны хамгаалал сайжран, тоо толгой нь өсөж, ургамал, эрвээхэй шавьж хорхойн төрөл зүйл нэмэгдэнэ. Усан сан, цөөрөм, хиймэл нуур олширно. Агаарын бохирдол арилна гэх мэт.

### Та Монгол орноор нэлээдгүй явсан байх, энэ тухай сэтгэгдэл? Хөдөө орон нутгаас юу олж мэдэж сурч авдаг вэ?

Хөдөө явах. Сайхан асуулт байна.



Зургийг Loes van Emden

Хөдөө орон нутагт манай орны нийт хүн амын тал хүрэхгүй хувь энэ улсын хамгийн гол ажлыг нугалж байна. Ялангуяа, манай байгаль орчны гол ажил хөдөө орон нутагт өрнөж байдаг. Хөдөөгийн хүн амын төлөвлөлтөөс авахуулаад, засаг захиргаа, салбарын анхдагч нэгждээ улсаас тодорхой хөрөнгө гарган бодлогоор боловсон хүчнээр бэхжүүлэх, хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах, тогтвор суурьшилтай ажиллуулах, эрх хэмжээ үүрэг хариуцлагыг нь нэмэгдүүлэх, улирлын чанартай ажлуудад ажилгүйчүүдийг дайчлан туслах хүч илгээх гэх мэт тодорхой ажлуудыг төр засаг нэн яаралтай зохион байгуулмаар байна. Одоо эргээд төвлөрөл бий болж, хөдөө орон нутагтаа анхаарал бага хандуулаад байх шиг санагдаж сэтгэлээ зовоож, оюунаа чилээж байна.

Манай хөдөөд жинхэнэ "Натур" монголчууд ажиллаж амьдардаг гэж боддог. Тэдний маань байгаль эх дэлхийгээ шүтэн нүүдэлчин ахуй, соёлын хэв ёсыг хадгалж уламжлалаа сахин байгальтайгаа ойр дасан зохицож амьдарч чадаж байна. Тэдний гайхамшигтай тэвчин хүлцэх, асар их нөөц чадавхи, жинхэнэ уужуу талбиун сэтгэлийг хүндэтгэн жинхэнэ "монгол хүмүүс" гэж үнэлдэг.

**Та Монгол орны хаана нь очих хамгийн дуртай вэ?** Монгол орны хаана ч очсон сайхан байдаг. Миний хувьд эх орон маань 4 улиралтайгаа бүхэлдээ сайхан. Онцлоод ялгаж салгаад байх юм алга.

## Хуудас 4

## ТЭТГЭЛЭГИЙН ЖИЖИГ ТӨСЛҮҮДТЭЙ ТАНИЛЦЛАА

Өнгөрсөн зун дэлхийн банкаас НЕМО2 төслийн хүрээнд хэрэгжиж буй зарим ажлын явцтай танилцахаар хөдөө орон нутагт гурван удаагийн аялал зохион байгуулсан юм. Аялалын явцад хэд хэдэн **тэтгэлэгийн жижиг төсөл**тэй танилцлаа. НЕМО-гийн тэтгэлэгийн жижиг төслийн хөтөлбөр нь ТББ, оюутны клуб, малчдын бүлэг гэх мэт олон нийтийн төлөөллийн байгаль орчныг хамгаалах санал санаачилгыг нь дэмжин тэтгэлэг олгодог. Жижиг төслүүд тэтгэлэгийн хугацаа нь дууссаны дараа ч **амжилттай үргэлжлэн хэрэгжиж** байна гэж дэлхийн банкны төлөөллүүд үнэлсэн байна. Зарим нь өөр эх үүсвэрийн санхүүжилт олсон байхад ихэнх нь өөрсдийн зардлаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байв. Тэдний нэг нь **цаасан хог хаягдлыг бууруулах төсөл** юм. 2010 онд Арвайхээр суманд

амжилттай хэрэгжсэн тул 2011 онд Хархоринд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхээр тэтгэлэг хүртсэн байна. Хог хаягдлыг дахиж ашиглах нь Монголд тийм ч нийтлэг ойлголт биш. Гэсэн ч уг төсөл энэ асуудлаар иргэдийн ухамсарт нөлөөлөхүйц ихээхэн ажил хийжээ. Тэдний зорилго нь орон нутагт хаягдал цаас цуглуулж боловсруулах, хог хаягдлыг **дахин ашиглахын** ач холбогдлыг хүүхдүүдэд ойлгуулах явдал юм. 2010 онд 30 гаруй тонн хаягдал цаас цуглуулж аймгийн ариун цэврийн цаасны үйлдвэрт тушаасан байна. Хаягдал цаас цуглуулдаг тусгай уут (1,7м X 0,77м) хийснээ биднийг очиход үзүүлсэн юм. Аймгийн захиргаа болон шуудангийн газар төслийн үйл ажиллагааг дэмжин хамтарч ажиллаж байна. Цаасан хаягдал, түүнийг ангилах талаар **зурагт хуудас** байрлуулж, дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрт ч тусгуулжээ. Орон нутгийнхан төслийн үр дүнд

сэтгэл хангалуун байна. Цаасан хаягдлыг цуглуулан тушааж орлого олж болохоос гадна байгаль орчинд ээлтэй гэдгийг **хүмүүс ойлгож эхэлжээ**. Уг төсөл ч цаасан хаягдлаас олсон орлогоороо үйл ажиллагаагаа санхүүжүүлэн цаашид нэмэлт санхүүжилтгүйгээр тогтвортой жижиг бизнес болон үргэлжлэх боломжтой юм.

Энэ бол НЕМО-гийн жижиг төслийн хөтөлбөрийн үр нөлөөллийг харуулах нэг жишээ юм.

Жижиг төслийн хөтөлбөрийн талаар мэдээллийг **world-bank.org/nemo** цахим хуудаснаас авна уу.



Хаягдал цаас цуглуулдаг уут (Э. Баясгалан)

## ХУУЛИЙН ХИЙДЭЛ, ДАВХАРДАЛ, ЗӨРЧЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад шинжлэх ухааны үндэслэлтэй, боловсруулалтын шаардлагыг сайтар хангасан байх зарчмыг баримтлан эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн төлөв байдлыг судлан тодорхойлж, **хийдэл, давхардал, зөрчлийг арилгах** замаар хуулийг боловсронгуй болгох"-оор заажээ. Энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор яам бүрт Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан салбарынхаа хийдэл, давхардал, зөрчлийг арилгах **ажлын хэсгүүд** байгуулагдан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд БОАЖЯ салбарын хууль тогтоомжийн уялдаа

холбоог сайжруулах зорилгоор НЕМО2 төслийн санхүүжилтээр зөвлөх баг авч ажиллуулан хуулийн хийдэл, давхардал, зөрчлийн үнэлгээ хийлгэлээ. Ажлын **үр дүнд** салбарын 23 хуулинд 129 хийдэл, 60 давхардал, 95 зөрчил илрүүлжээ. Үнэлгээний дүнг үндэслэн эдгээр **хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн санал** боловсрууллаа.



Зургийг Loes van Emden

## Байгаль орчны шинэчлэлд зориулсан Нидерланд-Монголын итгэлийн сан, хоёрдугаар шат

### HEMO2-ЫН ТҮҮХ

Байгаль орчны шинэчлэлд зориулсан Нидерланд—Монголын Итгэлийн сангийн эхний шат (**HEMO1**) 2005 онд байгуулагдсан юм. Хоёр дахь шат нь (**HEMO2**) 2007 онд 5 сая ам. долларын төсөвтэйгээр батлагдаж 2011 он дуустал үргэлжилнэ. Итгэлийн санг **Нидерландын засгийн газар** санхүүжүүлж, **Дэлхийн банк Монголын засгийн газартай** хамтран дараах чиглэлд захиран зарцуулж байна:

1. Байгалийн нөөцийн менежмент, 2. Бохирдлын менежмент, 3. Байгаль орчны засаглал. Энэ мэдээнд тусгагдсан бүх үйл ажиллагаа энэ 3 чиглэлийн хүрээнд хэрэгжиж байгаа болно.

• HEMO2 болон HEMO1-ийн талаар мэдээлэл, төслийн үйл ажиллагааны тайланг [www.worldbank.org/nemo](http://www.worldbank.org/nemo) цахим хуудаснаас олж үзнэ үү.



Зургийг Loes van Emden

### HEMO2 баг/Холбоо барих хаяг

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Ч.Жаргалсайхан, Дэд сайд, Төслийн үндэсний захирал  
Д.Энхээ, БОАЖЯ-ны хэсгийн зохицуулагч  
А.Энхцэцэг, ДБ хэсгийн зохицуулагч  
Р.Зоригоо, санхүүгийн менежер

Дэлхийн банк

Жэймс Райхэрт, Багийн ахлагч  
Б. Эрдэнэ-Очир, БО-ны асуудал эрхэлсэн ажилтан  
Сузанне Роелофс, Хөтөлбөрийн фасилитэйтор

#### Холбоо барих

Сузанне Роелофс  
sus\_roelofs@hotmail.com  
95738832

Л.Мөнхзул (БОАЖЯ, хэвлэл мэдээллийн ажилтан)  
info@mne.gov.mn / www.mne.mn  
11260718 - 88119821



Зургийг Koen Claes

WORLD BANK.ORG/NEMO